

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

Огноо: 2020 оны 04-р сарын 09-ний өдөр

Тендер шалгаруулалтын нэр: *Цогтцэций сумын төвөөс шинэ суурьшлын бүс хүртэлх хатуу хучилттай авто замын зураг төсөл боловсруулах*

Тендер шалгаруулалтын дугаар: ЭТТ/202001178

1. **Эрдэнэс-Тавантолгой ХК** нь *Цогтцэций сумын төвөөс шинэ суурьшлын бүс хүртэлх хатуу хучилттай авто замын зураг төсөл боловсруулах ажлыг* хэрэгжүүлэх зорилгоор зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь *Цогтцэций сумын төвөөс шинэ суурьшлын бүс хүртэлх 3 орчим километр хатуу хучилттай авто замын зураг, төслийг хийж гүйцэтгэхэд оршино. Үүнд:*

- a. Геодезийн ажлын тайлан,
- b. Инженер-геологийн судалгааны ажлын тайлан,
- c. Трассын захирамж, холбогдох техникийн нөхцлүүд,
- d. Авто зам, замын байгууламжийн инженерийн нарийвчилсан зураг төсөл,
- e. Зургийн тайлбар бичиг,
- f. Техникийн шаардлага,
- g. Ажлын нэр төрөл, тоо хэмжээ,
- h. Барилгын ажлын төсөв зэргийг холбогдох бүх байгууллагаар баталгаажуулан хуанлийн 80 хоногт багтаан хийх зэрэг болно.

3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох мэдээллийг ирүүлнэ. Үүнд:

1. *Тендерт оролцох сонирхлоо илэрхийлсэн болон уг хуулийн 14.1-д заасан нөхцөл үүсээгүй тухай мэдэгдсэн албан бичиг*
2. *Компанийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар*
3. *Авто зам, замын байгууламжийн техник-эдийн засгийн үндэслэл, инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах /2.8.1.2, 2.8.1.4, 2.8.1.5 аль нэг нь байж болно/ ажлын тусгай зөвшөөрлийн хуулбар /нотариатаар баталгаажуулсан байх/*
4. *Байгууллагын танилцуулга;*
5. *Татварын цахим тайлангийн системээс авсан татварын тодорхойлолт /Зөвлөхийн үйлчилгээ зарласан өдрөөс хойших байдлаар/*
6. *Харъяа Нийгмийн даатгалын санд өр төлбөргүй тухай Нийгмийн даатгалын газрын тодорхойлолт /Зөвлөхийн үйлчилгээ зарласан өдрөөс хойших байдлаар/*
7. *Иргэний хэргийн шүүхээс /Шүүхийн төрөлжсөн архив/ сүүлийн 3 жилийн байдлаар иргэний хэрэгт хариуцагчаар оролцож байсан эсэх талаарх тодорхойлолт /Зөвлөхийн үйлчилгээ зарласан өдрөөс хойших байдлаар/*
8. *Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд өр төлбөртэй эсэх талаарх тодорхойлолт /Зөвлөхийн үйлчилгээ зарласан өдрөөс хойших байдлаар/*
9. *Сүүлийн 3 жил буюу 2017, 2018, 2019 онуудын аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан*
10. *Сүүлийн 3 жил буюу 2017, 2018, 2019 онуудын хоёроос доошгүй жилүүдэд ижил төстэй зөвлөх үйлчилгээ үзүүлсэн болохыг тодорхойлсон гэрээ, гэрээ дүгнэсэн акт эсвэл үйлчлүүлэгчийн тодорхойлолт;*
11. *Зөвлөхийн багт ажиллах голлох мэргэжилтнүүдийн танилцуулга, боловсролын зэргийн диплом, НД-8 маягт (сүүлийн 2 сар буюу 2020 оны 1, 2 сарын)*

4. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг **2020 оны 04-р сарын 17-ны 17:00 цагийн** хооронд авч болно. Мэдүүлгээ **2020 оны 4-р сарын 20-ны 10:00** цагийн дотор Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn хаягаар цахимаар ирүүлнэ үү.

“Эрдэнэс-Тавантолгой” ХК
Жигжиджав-8, Финанс төв, 5 давхар
Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо
Улаанбаатар хот,
Утас: 7505-5555 дотуур утас-507